

2.3. СОЁЛЫН АДЛСАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Соёл нь хүний үйл ажиллагааны үр дүн гэдэг утгаараа тухайн соёлын тээгч, бас бүтээгчээсээ ангид байх боломжгүй юм.


Даяаршлын үед оршин тогтнох чадварын хувьд хамгийн тогтвортой, хамгийн найдвартай тээгчид бол угсаатан юм.

Тэдний түүх, зан заншил, сэтгэлгээний онцлог, үнэлэмжийн баримжаалал, хэл, бичиг үсэг, урлаг, уран зохиол багтана.

01

02

03



СОЁЛЫН АДИЛСАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Ард түмэн өөрийн соёлын хэм хамжээ, зан үйл, хэл, үнэлэмжийн баримжааллыг ухаарч ойлгох, тэрхүү байр сууринаас өөрийгөө ойлгох, тэрхүү соёлыг тээгч гэдгээ ухаарах байдлыг **соёлын адилсал** гэнэ.



ХАРИЛЦАН АДИЛГҮЙ

Үнэхээр татагдам, гайхалтай, хүчирхэг эсвэл ойлгоход төвөгтэй, хачин жигтэй, дургүй хүрмээр гэх зэргээр төсөөлөгддөг.



ДАГАН ДУУРИАХ

Бусдын соёлыг улам бүр эрхэмлэх, аль эсвэл бусдын соёлд автагдах буюу мухар сохроор даган дууриах



УГСААТАН

Өөрийгөө угсаатан гэдэг утгаар нь хадгална гэдэг нь угсаатан бүрийн эрхэм дээд чиг үүрэг



УГСААТНЫ СОЁЛ

Угсаатныхаа онцлогийг хадгалах мэдрэмж, хүсэл эрмэлзэл нь дэлхийн бусад ард түмэнтэй харилцан хамааралтай болох үед идэвхждэг.



ДАЯАРШИЛ

Уламжлалт соёл, байгалийн нөөц, баялаг бүхий буурай хөгжилтэй улс орнууд дэлхийн түүхий эдийг бэлтгэгч орон болдог.



СОЁЛЫН ХАРИЛЦАА

Соёлын харилцаа өргөжиж хүрээгээ тэлэхийн хэрээр тусгаар үндэс, соёл, ёс заншил, уламжлал шашнаа хэвээр нь авч үлдэх

СОЁЛЫН ДАРХЛАА

Бусдын соёлд үл
автагдах, үнэт зүйлсээ
хадгалж үлдэх асуудал
МӨН.



Улс үндэстэн бүр өөрийн соёлыг эрхэмлэдгийн учир юунд орших вэ?

- үндэстнийг бусдаас ялгах гол шинж учраас
- ард түмний бахархал, омогших хүч учраас
- үндэстний эв нэгдлийн үндэс учраас
- үндэстний тусгаар тогтнолын баталгаа учраас

Улс үндэстэн бүр өөрийн соёлыг хадгалж үлдэхийн тулд яах ёстой вэ?

- эрин цагийнхаа түүхэн хандлага, өөрчлөгдөж байгаа гадаад орчиндоо зохицож, зохих хэмжээ, хязгаарын дотор шинэчлэгдэж байх
- өөрийг нь бусад соёлоос ялгаж буй язгуур ба уламжлалт чанараа хадгалж, хамгаалах

Соёлын дархлаа сулардаг гол шалтгаан юу вэ?

- бусдын соёлыг хуулбарлан дуурайх
- өөр соёлын зүгээс соёлын тулгалт хийх

Бүдүүвч 2.5. Соёлын дархлааны утга учир



Гэртээ хийгээрэй. Дараах мэдээллийг уншаад асуултын дагуу ажиллаарай

Телевизийн сувгууд олон түмнийг залж, өөртөө татахын тулд тархийг нь угаан сэтгэхүйг нь дундажчилж байна. Өнөөгийн олон түмний тархи сэтгэхүй нь залхууралд орж, хов жив, сураг ажиг төдийхнөөс давахаа болилоо. Энд цахим орчин ч зарим талаар гавшгайлан довтлогч, хөнөөн сүйтгэгч боллоо. Хэрэв хүнийг өдөр бүр телевизийн дэлгэц болон дэлхийн цахим сүлжээний шүүлтүүр муутай мэдээллээр угжаад байвал хүний, түүний эргэн тойрныхны соёлын дархлаа суларч, бүр алдагдах нь илэрхий.